

Оюу толгой уурхайн зэсийн баяжмалын экспорт эхэллээ

Жан Себастьян Жак

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэж, өнөөдрийн түүхэн ач холбогдолтой үйл явдалд хуран цугларсанд талархал илэрхийлье. Манай ёслолд хүрэлцэн ирж, бидэнтэй хамт байсан Монгол улсын Ерөнхий сайд эрхэмсэг ноён Алтанхуяг, Уул уурхайн сайд Ганхуяг, бусад хүндэт зочдод гүнээ талархаж байна. Монгол Улсад, нийт Монголын ард түмэнд энэ ялдамд талархал илэрхийлье.

Оюу Толгой шиг дэлхийн түвшний асар том уурхай үйлдвэрлэлээ эхлүүлэх нь ховор байдаг. Энд хүрэлцэн ирсэн нь бахархалтай, бас хүндэтгэлтэй зүйл байна гэж санагдаж байна. Рио Тинтод бүх групп компанийн хамт олны нэрийн өмнөөс, Оюу Толгойн ажиллагсдад болон Монголын ард түмэнд баяр хүргэе.

Оюу Толгойн хувьд энэ бол урт, удаан аялал байлаа. Анхны нээлт хийсэн мөчөөс бараг 12 жил өнгөрлөө. Энэ нь удаан санагдах боловч, бидний төсөөлж буй 50 гаруй жилийн ашиглалтын хугацааны багахан л хэсэг юм. Энд цугларсан та бид энэ хугацаанд гарах сорилт, тулгарах бэрхшээлүүдийг хамт даван туулахын төлөө эрч хүчтэй ажиллах хэрэгтэй юм. Бид өөрсдийнхөө төлөө биш, бидний хойч үе, үр хүүхдийнхөө төлөө энэ хөрөнгө оруулалтаа хийж байгаа нь ойлгомжтой.

Нэгэн зорилгын төлөө хамтран ажиллах нь сайн түншлэлийн суурь болдог. Энэ суурин дээр үндэслэн Өмнийн говийн нутагт боссон энэ үйлдвэрийг 21 зууны эрдэс баялгийн салбарт тэргүүлэх үйлдвэр болж дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөнө.

Баяжмалын экспортор эхлүүлж байгаа энэ мөчид, бидний олон түнш энд хүрэлцэн ирж цугларсан билээ. Бид хамтдаа урт удаан, ололт амжилт дүүрэн аялалыг эхлүүлж байгаа гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Энэ үйл явц нь тийм ч амар биш гэдгийг өнөөдөр бид сайн мэдэж байгаа. Ил уурхайгаас хүдрээ олборлоод, баяжуулах үйлдвэр лүү тээвэрлэж, чанартай, эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн бий болгоход түмэн олон нарийн үйл явц шаардлагатай гэдгийг бид бүгд сайтар ойлгож байна.

Баяжмалын экспортоо эхлүүлэх нь чухал ач холбогдолтой хэдий ч, энэ бол бидний түншлэлийн хувьд зөвхөн нэг алхам байх болно.

Оюу Толгойн хувьд өнөөдрөөс эхлэн, дараагийн үе шат, дараагийн алхам болох ажлыг нүдээрээ харж үзэлгүйгээр төсөөлөх аргагүй билээ.

Дэлхийн хамгийн сайн зэс-алтны ордуудын нэг нь энэ газрын дор мянга гаруй метрийн гүнд бий. Өндөр чанарын, маш том, маш нарийн орд билээ. Энэ ордыг олборлож амжилттай ашиглалтад оруулахад нэг л арга зам бий.

Оюу Толгойн блокчлон олборлох гүний уурхай бол дэлхийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологи бүхий гүний уурхай байх болно. Бидний ашиглах блокчлон олборлох аргын хамгийн тэргүүний туршлагыг Рио Тинто энд нэвтрүүлж

байна. Энэ бол Монголд өмнө нь хэзээ ч хүрч байгаагүй гүнээс хүдрийг олборлох эдийн засгийн хувьд үр ашигтай, хамгийн аюулгүй арга барилыг хэрэглэнэ гэсэн үг.

Энэ бол тийм хялбар зүйл биш бөгөөд энэхүү бүтээн байгуулалтыг бий болгоход олон улсын төслийн санхүүжилт шаардагдана. Гэхдээ гүний блокчлон олборлох арга бол энэ уурхайг дэлхийн бусад зэсийн уурхайгаас онцлох зүйл мөн. Оюу Толгойг энэ төсөлд шууд болон шууд бусаар оролцсон хүн бүрт ашиг тусаа өгөх олон үе дамжсан уурхай гэж нэрлэгдэх болсон шалтгаан нь энэ билээ.

Оюу Толгой бол Рио Тинто компанийн хувьд тэргүүний уурхай болоод зогсохгүй Монголын ард түмний хувьд ч тэргүүний үйлдвэр болох ёстой. Бид энэ төсөл юу хийж болохыг харуулах тод жишээ болгохын төлөө ажиллаж байдаг. Энэ бол дэлхийд ховорхон ажлыг аюулгүйгээр хийж гүйцэтгэх ажлын байр байх болно.

Бидний үүрэх ачаа их, хүлээх хариуцлага өндөр байна. Иймд бид энэ төслийн төлөө, хүн бүр үүний ашиг шимээ хүртэхийн төлөө, Оюу Толгой амжилтад хүрэхийн төлөө ажиллах болно.

Өнөөдөр бид зэс, алтны экспортоо эхлүүлж байгаа нь үүнийг хийж болно гэдгийг харуулж байна. Бүх түвшний төрийн байгууллагуудад Оюу Толгойгоос төлсөн 1 гаруй тэрбум ам.долларын татвар, төлбөрийн бодит орлого үүнийг нотолж байна. Энд цугларсан бидний ажиллагсад болон бэлтгэн нийлүүлэгчид, мөн Оюу Толгойн сургалтын хөтөлбөрт хамрагдсан мянга мянган залуус энэ уурхайгаас олох ашиг шим нь ямар өргөн хэмжээнд дэлгэрч, хүмүүсийн аж амьдралд хэрхэн эерэгээр нөлөөлж байгааг харуулж байна.

Бид цаашид улам их амжилтад хүрч, энд эхэлсэн ололт амжилттай аян замыг хамтдаа үргэлжлүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Эцэст нь, аливаа ажилд өөрийн болон хамтран ажиллагсадын аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд тавьж ажиллахыг та бүгдээс хүсч байна. Аюулгүйгээр хийж болохгүй чухал ажил байх ёсгүй.

Та бүгдэд талархалаа илэрхийлэн та нарын бүтээж бий болгосон гайхамшигт ажлын амжилтад дахин баяр хүргэе.

Сайн сайхныг хүсэн ерөөе.